

**“УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар тогтоолын төсөлд тусгагдсан зарим асуудлыг төслийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх, хасах, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон шалтгаанаар зогссон төслүүдийн талаар судалж, 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах, Төсвийн тухай хуулийн 29^{1.4}-т заасан цахим систем дэх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүд нээлттэйгээр харах боломжийг бүрдүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртөг нь 50-аас дээш хувиар нэмэгдсэн төслүүдийн талаар Засгийн газраас судалж, Улсын Их Хуралд танилцуулахтай холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 47.1 хувь буюу олонх дэмжээгүй бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын

хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн
шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Н.НАРАНБААТАР